

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРААС “МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”-ЫН ӨӨРТ ХАМААРАХ ЗААЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2023.05.30

Дархан-Уул аймаг

№	Заалтын дугаар	Үндэсний аюулгүй байдлыг хангах арга зам	Хэрэгжилт	Хувь
1	1.1.6	Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн.	<p>1.Төвийн бүсийн соёл, урлагийн байгууллагын ажилтнуудын дунд зохион байгуулсан “Шагайн харваа” тэмцээн 2023.01.14-15-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 100 гаруй шагай харваачид оролцсон. Улсын мэргэн харваач Ш.Долгор нь өөрийн хийсэн шагайн харвааны хэрэгслээ аймгийн Музейд хандивласан.</p> <p>2. Аймгийн Хүүхдийн номын ордон “НОМЫН БОГЦ” аялуулж, ерөнхий боловсролын 6 сургуулийн бага ангийн 9 бүлэгт 400 гаруй боть номыг зөврөөр хүргэн үйлчилсэн.</p> <p>3. “Оюунлаг Дарханчууд” дэд хөтөлбөрийн хүрээнд “ХАМТДАА УНШИНА, ХАМТДАА ХӨГЖИНӨ” өдөрлөгийг Орхон сумын Соёлын төвтэй хамтран зохион байгуулж, 150 гаруй сурагчийг хамруулж, номын санчдыг мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.</p> <p>4. Эх орныхоо өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, бахархах, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх зорилготой Монгол орон даяар өрнөсөн “МУЗЕЙН НЭЭЛТТЭЙ ӨДРҮҮД”-ийг 5 хоног зохион байгуулж, 1629 хүнд үйлчилж, 8 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулсан.</p> <p>5. Музей нь монголын уламжлалт “ҮЙЧҮҮР” тоглоомыг хүүхэд, багачуудад, иргэд олон нийтэд зааж сургах хөтөлбөрийг тогтмол зохион байгуулж хэвшсэн.</p> <p>5. Ардын бий биелгээний арга барил, биелэх онцлог, зан үйлийн боловсрол олгох, соёлын биет бус өвийг өвлүүлэн уламжлуулах зорилгоор “УГСААТАН БИЙ” төслийн хүрээнд сургагч багш бэлтгэх болон сонирхогчийн гэсэн 2 ангид 15 хоногийн турш тасралтгүй хичээллэсэн 80 суралцагчид батламж олгосон. Үүнээс зургаан угсаатны бий биелгээг заах эрхтэй 17 сургагч багш бэлтгэгдсэн.</p> <p>6. Аймгийн Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлөөс санаачлан “ӨВ СОЁЛОО ӨВЛӨН УЛАМЖИЛЪЯ” зүү ороох хатгамлын сургалтад ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг хамруулж эхэлсэн.</p> <p>7. Төв номын сан соёлын боловсролын “МОНГОЛ БАХАРХАЛ” хөтөлбөрийг</p>	100%

			<p>нийтдээ 12 удаа зохион байгуулан 377 хүнийг хамруулж, оролцогчдод сампин зангидаж, номын хавчуурга хийж, “Үндэсний өвийг уламжилъя” сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж толилуулсан.</p> <p>8. Тэгш хүртээмжтэй нийгмийг цогцлоох, Монгол үндэстний ижилсэл ба ялгарлыг дэлхийд таниулах зорилготой “ТРИО” киноны нээлтийг Дархан-Уул аймагт зохион байгуулахад хамтран ажилласан.</p> <p>9. Монгол нохойг устаж, ховордохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, үржүүлэх, нутагшуулах зорилгоор “ДАРХАН ТАЙЖ ХАСАРЫН НЭРЭМЖИТ ТӨВИЙН БҮСИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ҮЗЭСГЭЛЭН ТЭМЦЭЭН”-ийг 2022.04.22-ны өдөр Дархан хотноо зохион байгуулсан. Монгол нохойн үзэсгэлэн, тэмцээнд ОХУ-ын Буриад, УБ, Эрдэнэт, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай, Дархан-Уул аймгаас нийтдээ 71 ноход оролцсон.</p> <p>10. “Соёлын өв” улсын уралдааны II шатны шалгаруулалтыг явуулж шалгарсан 6 хүүхдийн эссэг III шатны шалгаруулалтад оруулахаар СУИС-ийн цахим хаягаар явууллаа.</p> <p>11.“Соёлын өв” улсын эчнээ олимпиадын хүрээнд Шарын гол сумын 2 дугаар сургуулийн “Сэтгэмж” мэтгэлцээний клубийн сурагчид" ӨВ СОЁЛОО ХАЙРЛАН ХАМГААЛЦГААЯ" уриатай “БУГАН ЧУЛУУН ХӨШӨӨ”-ний эргэн тойрныг хамт олноороо цэвэрлэж ирсэн бөгөөд энэ жил хашаа, танилцуулгыг будаж шинэчиллээ.</p> <p>12. "Угсаатан бий" төслийн сургалтыг төгссөн хүүхдүүд "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр" буюу 2023.06.01-ний өдрийн баярын нээлтэд 17 хүүхэд оролцож бий биеллээ.</p>	
2	1.2.1	<p>Эх оронч үндэсний үзлийг дээдлэх Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн</p>	<p>1. Хүүхэд, залуучуудад эх орноороо бахархах, итгэл үнэмшил төрүүлэх, биеэ зөв авч явах, багаар ажиллах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, амьдралын зөв дадал, чадварыг эзэмшүүлэх зорилгоор "БИД ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ" төслийн хоёрдугаар шатны нээлтийн хүрээнд 2023.03.16-ны өдөр Залуучууд театрт “<b>Эх оронч үзлийг төлөвшүүлэх нь</b>” өдөрлөгийг зохион байгуулахад хамтран ажилласан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Залуучууд театрын уран бүтээлчид “Эх орны хүү” урлагийн тоглолтыг толилуулсан.</li> <li>-Музей “Халх голын түүхэн ялалт” түр үзэсгэлэн гаргаж, байлдааны нисдэг цаасан онгоц хийх боловсролын хөтөлбөрт 30 гаруй насанд хүрэгч, 400 гаруй хүүхэд, боловсролын хөтөлбөрт 50 хүүхэд оролцож сурсан.</li> <li>-Төв номын сан "Монгол цэргийн өдөр" сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргаж, уншигчийн үнэмлэх нээж, ном солилцоо хийж, "Бэлэгтэй асуулт" буланг</li> </ul>	100%

		идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно.	<p>ажиллуулан 18 хүүхдийг урамшуулав.</p> <p>-Хүүхдийн номын ордон “Монгол цэргийн өдөр”-т зориулан цэрэг эх орны сэдэвчилсэн номын үзэсгэлэн гарган уншлага зохион байгуулж, 150 гаруй сурагчийг хамруулж, уншигчийн картыг хөнгөлөлттэй үнээр нээж, 6 уншигч шинээр бүртгэсэн.</p> <p>-Зэвсэгт хүчний 330 дугаар цэргийн анги сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж, фото зон татаж, техник төхөөрөмжтэй танилцах хөтөлбөрийг зохион байгуулсан.</p> <p>-Тус газраас Ардын хувьсгалын 102 жилийн ойг бэлгэдэн ахлах ангийн 102 сурагчдын дунд “АХА” тэмцээнийг зохион байгуулж, тэмцээнд оролцсон хүүхэд бүрд чихэр, сүүлийн 20 хүүхдэд ном, 1, 2, 3 дугаар байранд шалгарсан сурагчдад Өргөмжлөл, дурсгалын зүйлийг гардуулав.</p> <p>-Энэхүү өдөрлөгт ЕБС-ийн ахлах ангийн нийт 500 гаруй сурагчид хамрагдсан байна</p> <p>2. Аймгийн Засаг даргын нэрэмжит “БИД ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ” төслийн хоёрдугаар шатны хаалтыг 2023.05.29-ний өдөр зохион байгуулахад тус газраас тусгай байранд шалгарсан 13 хүүхдэд ном, гарын бэлгийг Төв номын сангаар үйлчлүүлэх эрхийн бичгийн хамт гардуулж урамшуулсан.</p> <p>3. Сурагчдыг сэтгэлгээгээ өөрчлөх, хувь хүний хөгжил, байгаль дэлхийгээ хайрлах, өөрийн дотоод мөн чанар, өөрийгөө олж нээх боловсрол олгох зорилгоор 21 аймагт хэрэгжүүлж буй “MIND UPDATE” төслийг 2023.03.21-ний өдөр Дархан-Уул аймагт зохион байгуулж, 500 орчим хүүхэд хамрагдлаа.</p>	
3	3.1.4	Соёл иргэншлийн аюулгүй байдал.	<p>-“Нээлттэй Дархан” хөтөлбөрийн хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл кино урлагийн салбарыг орон нутагт хөгжүүлэх, дэмжих, сурталчлан таниулах, кино бүтээгчдэд зураг авалт хийх таатай орчин бүрдүүлсэн “КИНОНД ЭЭЛТЭЙ ХОТ” болох зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023.04.10-ны өдрийн 01-А/105 захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. 2023.05.03-ны өдөр Соёлын яам болон Монголын кино урлагийн зөвлөлийн төлөөлөгчид тус аймагт ажиллаж, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав. 2023 оны 09 дүгээр сард “Соёлын сэргэлт-2023” аяныг тус аймагт зохион байгуулахтай холбогдуулан кинонд ээлтэй хот болох тухай “Санамж бичиг”-ийн төслийг боловсруулан Соёлын яаманд хүргүүлээд байна.</p> <p>-Хүүхдийн номын ордон өөрийн гэр бүлийн түүхээ үеэс үед, үр хүүхэддээ өвлүүлэн ухааруулах зорилгоор УГИЙН БИЧИГ ХӨТЛӨХ сургалтыг зохион байгуулж эхэлсэн.</p> <p>-Музей, Орхон сумын Соёлын төв хамтран аймгийн гэрэл зурагчдын бүтээлээр “ДАРХАН ХОТЫН ХӨШӨӨ ДУРСГАЛ-МИНИЙ ДУРАНД” гэрэл зургийн үзэсгэлэнг</p>	100%

		<p>дэлгэж, “Бугат чулуу” боловсролын хөтөлбөрт 100 гаруй хүнийг хамруулсан.</p> <p>-Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын хүрээнд Төв номын сангаас төрийн алба хаагчдад зориулан “Миний Монгол бичиг” сургалт, өдөрлөгийг зохион байгууллаа. Сургалт, өдөрлөгийн хүрээнд “Үндэсний бичиг үсгийг САВ, ШИМ ертөнцийн юмс, үзэгдэлтэй холбон таних арга ба үр дүн”, “Мянган жилийн буурал түүхтэй Монгол бичиг соёлоо судалцгаая” сэдвээр лекц тавьж, Төв номын сан 100 гаруй боть номоор “МОНГОЛЧУУДЫН ЭРТНИЙ БИЧГИЙН СУРВАЛЖ СУДАЛГАА” сэдэвчилсэн номын үзэсгэлэн, Музей “МОНГОЛЧУУДЫН ХЭРЭГЛЭЖ ИРСЭН БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ” үзэсгэлэн, 30 дугаар сургууль, Од цогцолбор сургуулийн багш, сурагчдын бүтээлээр үзэсгэлэн гаргаж, монгол хэл, бичгийн соёлоо хамгаалан хөгжүүлэх, уламжлалт монгол бичгийн сургалт, хэрэглээг нэмэгдүүлсэн.</p> <p>-“Хос бичигтэн төрийн албан хаагч” уриан дор тус газрын 8 албан хаагч сургалтад хамрагдсан.</p> <p>-Бүх нийтийн соёлын боловсролын чиглэлээр нийтдээ 17 удаа 1321 ботиор “СЭДЭВЧИЛСЭН НОМЫН ҮЗЭСГЭЛЭН” гаргаж, 5787 иргэнд үйлчиллээ.</p> <p>-Аймгийн ЕБС-иудын дунд “ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛЬЕ” урлагийн наадам зохион байгуулагдаж, 60 гаруй сурагчид эх орны сэдэвт гоцлол дуу, хамтлаг дуу, бий биелгээ, багийн асуулт, хариулт, жүжигчилсэн тоглолтоор өөр хоорондоо өрсөлдөв.</p> <p>-Монголын шог зураачдын “ШОГЧ БИЙР” холбоо, Монголын Эмнести Интернэшнл байгууллагатай хамтарсан “Цаг уурын өөрчлөлт”, “Цар тахал ба хүний эрх” сэдэвт асуудал хөндсөн шог зургийн үзэсгэлэнд 19 шог зураачийн 123 бүтээл дэлгэгдэж, 359 хүүхэд, 128 насанд хүрэгчид толилуулсан байна.</p>	
<b>ДУНДАЖ ХУВЬ</b>			<b>100%</b>

**НЭГТГЭСЭН: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА С.ТУЯА**